

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.10.31, №5 (121)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№503

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

СААРАЛ НИЙГЭМ



ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Ц.Батболд

Хөгжлийн эдийн засагч (PhD),
олон улсын хуульч

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БА МОНГОЛ

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ ИХ СУРГУУЛИУДЫГ НЭГТГЭХ
НЬ ЗӨВ

➤ СААРАЛ ЖАГСААЛТАД ХЭН
ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ВЭ?

➤ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ОРЧИН: ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

VI НҮҮРТ



Чөлөөтэйгээр эвлэлдэн нэгдэх эрхийг монголчууд ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд баталсны дараа л жинхэнэ утгаар нь эдэлж эхэлсэн. Таван жилийн дараа Төрийн бус байгууллагын (ТББ) тухай хууль батлагдаж иргэний нийгмийн байгууллагууд бие даасан хуультай болов. Арван жилийн өмнөөс жил бүрийн 1-р сарын 31-ийг Иргэний нийгмийн өдөр гэж тэмдэглэдэг болсон. Эдүгээ олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20-оод мянган ТББ бүртгэгджээ.

Иргэний нийгмийн байгууллагын гол зорилго бол иргэд төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хууль гарахаас өмнө судалгаанд суурилсан санал бодлоо илэрхийлж, ардчилал, нийгмийн дэвшил, хүний эрхийг хамгаалахад оршдог. Монголын иргэний нийгэм ямар байгааг олон улсын "Civicus" байгууллагаас судлаад учир дутагдалтай, дунд гэж дүгнэжээ.

ИРГЭНИЙ НИЙГЭМ ӨНӨӨДӨР

Монголд иргэний нийгэм сул, хөгжүүлэх, засч сайжруулах шаардлагатай гэдгийг ТББ, төр засаг нь ч хүлээн зөвшөөрч байна. Юуны өмнө ТББ-уудыг дэмжихийн тулд хуулиа сайжруулах шаардлагатай гэж хоёр тал үзэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас *"Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл"*-ийг боловсруулав. Энэ төслийг хэлэлцэхээр хууль санаачлагч тал (ХЗДХЯ) болон иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан цуврал уулзалтууд болов.

ТББ-ын төлөөллүүд нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-уудыг, өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалахаар нэгдсэн мэргэжлийн, ►►

▶ болон эдийн засгийн холбоодтой нэг саванд оруулж болохгүй гэж үзэж байна. Улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүд, залуучуудын холбоо нь ч ТББ-ын бүртгэлтэй байна. Эдгээр байгууллагууд төрөөс хараат бусаар сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн, ашиг олдоггүй зэргээрээ адилхан нь үнэн. Гэхдээ хэнд үйлчлэх, юуны төлөө нэгдэж үйл ажиллагаа эрхэлж байгаа гэдгээрээ зарчмын ялгаатай.

Иргэний нийгэм нь төрөө хараат бусаар хянаж чаддаг механизм учир ардчиллын орлуулж болдоггүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Зарим оронд төрийн

үйлчилгээний тодорхой чиг үүргийг гэрээгээр ТББ-аар гүйцэтгүүлж хамтран ажилладаг. Тийм учраас олон оронд төр нь иргэний нийгмийн байгууллагуудаа ихэвчлэн татварын орчноор дэмжиж, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Герман зэрэг оронд үйл ажиллагааны зардлыг нь төсвөөс санхүүжүүлдэг. Манай улсад ТББ-ууд улсын болон орон нутгийн дэмжлэг авдаггүй, нийт санхүүжилтийнх нь 2 хувийг төрөөс гаргаж байна. Нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд, ажилчид нийгмийн даатгалын шимтгэл дээр ямар ч хөнгөлөлт эдлэхгүй байна.

ҮЗЭЛ БАРИМТЛАЛГҮЙ ТӨСӨЛ

Манайд иргэний нийгэм гэж юуг ойлгох вэ гэдгээс эхлээд олон зүйл тодорхойгүй байна. Иргэний нийгмийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг олгоно гэдэг ч бодитой хийсэн ажил алга, нэр томъёогоо ч тодорхойлоогүй байна.

Уг нь энэ бүхнийг тодорхой болгох үүднээс 2011 онд Сү.Батболдын Засгийн газар төр, иргэний нийгмийн хамтарсан ажлын хэсэг байгуулж “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл анх удаа боловсруулжээ. Тэр төсөлд нийт аймаг, нийслэл дэх ТББ-уудын саналыг авсны дараа Төрийн ордонд хэлэлцүүлэг хүртэл зохион байгуулжээ. Гэвч 2012 оны сонгуультай давхцаж, шинэ Засгийн газар байгуулагдсанаас хойш тэр төсөл замхарсан аж.

Энэ удаа ТББ-ын тухай шинэ хуулийн төслийг Их хуралд оруулахаасаа өмнө иргэний нийгмийн тухай үзэл баримтлалаа шинэчлэн хэлэлцүүлэх шаардлагатай байна. Үзэл баримтлалаа баталсны дараа хуулиа хэлэлцвэл иргэний

нийгмийн хөгжилд зөв түлхэц болно.

Манай улсыг саарал жагсаалтад саяхан оруулсан ФАТФ байгууллагаас тавьж буй нэг шаардлага нь “Террористууд, террорист байгууллагууд, терроризмыг санхүүжүүлэгч нь ашгийн бус байгууллагуудаар дамжуулж хөрөнгө босгох, шилжүүлэх, хэрэглэхээс хамгаалах” гэжээ. Энэ шаардлагын дагуу “Ашгийн бус хуулийн этгээдийн тухай” хуулийн төслөө яаравчлан өргөн барихаар зэхэж байна. Үнэхээр төрийн бус байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй байгаа бол өөр хуулиар шийдэгдэх ёстой. Ер нь саарал жагсаалтад орсны гол шалтгаан бол хууль журам байхгүйдээ биш, хуулиа хэрэгжүүлэхгүй, сахиулж чадахгүй байгаатай холбоотой.

Хууль тогтоогчид монгол хэт олон төрийн бус байгууллага, хэт олон намтай болчихлоо гэдэг. Гэтэл үнэндээ монголд Унгар, Польш зэрэг пост коммунист орнуудтай харьцуулахад улс төрийн намуудын тоо ч, төрийн бус байгууллагуудын

тоо ч харьцангуй цөөхөн байна. Үүнийг Дефакто Институтын хийсэн “ТББ-ЫН ИНСТҮҮЦИЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ: МОНГОЛ, УНГАР, ПОЛЬШ ОРНУУДЫН ЖИШЭЭН ДЭЭР” -ээс харж болно.



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ИНСТҮҮЦИЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Монгол, Унгар, Польш орнуудын жишээн дээр

Олон байгаа нь өөрөө асуудал биш. Харин ч давуу тал.

Ардчиллын нэг тулгуур багана иргэний нийгмийг хөгжүүлэхийн төлөө хүн бүр хичээн зүтгэх шаардлагатай байна.

2019.10.31

ДАРАА ТӨЛБӨРТ

шинэ хэрэглэгчид

БАРЬЦАА ТӨЛБӨР
БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ

0 ТӨГРӨГ

ЯРИА

Сүлжээндээ хязгааргүй

7.000₮

Сүлжээндээ хязгааргүй
Бусад сүлжээнд 250 минут

17.000₮

Сүлжээндээ хязгааргүй
Бусад сүлжээнд 1000 минут

27.000₮

ДАТА

Хязгааргүй 2GB

12.000₮

Хязгааргүй 10GB

28.000₮

Хязгааргүй 5GB

20.000₮

Хурд, хэрэглээний хязгааргүй

42.000₮

МЕССЕЖ

Сүлжээндээ өдөр бүр 200ш

2.000₮

Сүлжээндээ өдөр бүр 200ш
Бусад сүлжээнд сард 500ш

4.500₮



Ц.Батболд

Хөгжлийн эдийн засагч (PhD), олон улсын хуульч

ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БА МОНГОЛ

Хөдөө аж ахуй үүсч хүмүүс өдөр тутмын хэрэгцээнээсээ давсан хүнс үйлдвэрлэх болсноор суурьшиж, зарим нь гар урлал, худалдаа, шүтлэг, боловсрол, удирдлага зэрэг ажил эрхэлж илүүдэл хүнсээ өөр бараагаар солилцох болсноор зах зээлийн харилцаа хэдэн мянганы тэртээ эхэлжээ. Харин эдийн засгийн хөгжил буюу нэг хүнд ногдох дундаж бүтээгдэхүүн ба орлогын өсөлт бол хүн бүр хөрөнгө эзэмшиж, хөдөлмөрөө зарах эрхтэй болсон капиталист харилцаа, тэндээс олох ашгийг улам нэмэгдүүлэхийн төлөөх аж үйлдвэржилтийн (хувьсгал ч гэдэг) үетэй холбоотой сүүлийн 200 гаруйхан жилийн үзэгдэл юм.

500 жилийн өмнө дундаж цалин хаана ч бараг адил, амь зогоох хэмжээнээс дөрөв орчим дахин их байсан гэдэг бол 1820 он гэхэд Голланд, Англи зэрэг түрүүлж хөгжсөн орнуудад 50 нугалах түвшинд хүрчээ. Үүнд байгалийн баялагаа эдийн засгийн эргэлтэд оруулах явдал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Анх модоо барж үнэ нь өндөрсөхийн дагуу Англид нүүрс, Голландад хүлэр, Америкт нефть олборлож эхэлсэн нь эдийн засгийн бүтцийг өөрчилж, хөгжлийг эрс түргэсгэх гол эх үүсвэр болжээ. Жишээ нь 1800-аад оны эхэнд АНУ-ын хүн амын 90 гаруй хувь нь хөдөө аж ахуйд ажиллаж байсан бол 1880 он гэхэд 50 хувь болж буурсан ч хөдөө аж ахуй, уул уурхайн анхан шатны салбар ҮНБ-ий 23 хувь буюу аж үйлдвэрээс арай илүүг үйлдвэрлэх болжээ. Хөгжлийн явцад орон бүр энэ шатыг дамжсан бөгөөд уламжлалт хөдөө аж ахуйгаасаа ингэж шилжиж дэвшиж чадаагүй нь өнөөгийн буурай хөгжилтэй орнууд болсон байна. (Саяхан хүртэл хамгийн хоцрогдсон бөглүү газар бол Гадаад Монгол гэсэн ойлголт гадаадад түгээмэл байсныг бид тэр болгон мэддэггүй)

УЛАМЖЛАЛТ ХӨДӨӨ АЖ АХУЙ

Уламжлалт буюу үе дамжсан нэг л аргаар айл бүр амиа аргацаасан хөдөө аж ахуй нь бүтээмж багатайн зэрэгцээ, цаашид хөгжих зах зээлийн солилцоо, ашгийн түлхүүр сул учир эдийн засаг, нийгмийн хөгжлийг зогсонги болгох нөлөөтэй байдаг. Энэ тухай Кариб гаралтай Манчестерт багш байсан Нобелийн шагналт хөгжлийн эдийн засагч А.Луисийн “dual” буюу “хоёрдмол” эдийн засаг онол байдаг. Ийм аж ахуй нь эдийн засаг төдийгүй ахуйн зонхилох хэлбэр болж хүн бүрийг ажилтай амьдралтай байлгах мэт боловч, эдийн засгийн

үр ашгийн үүднээс бол асар их илүүдэл ажилчинтай, тэр утгаараа хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүн нь маш бага, үндсэндээ тэгтэй тэнцэж байдаг. Энэ нь бусад салбар хөгжихөд хямд ажлын хүчээр хангах, цалингийн ерөнхий түвшинг нам байлгаснаараа олон улсын зах зээлд өрсөлдөх боломж дээрдүүлэх ач холбогдолтой боловч өөрөө зах зээлийн үр ашгийн тооцоонд орж, бусад салбарыг түүхий эдээр хангадаг эрчимжсэн аж ахуй болохын тулд чанарын гүнзгий өөрчлөлт шаарддаг. Жишээ нь өнөөдөр АНУ-ын хөдөө

аж ахуйн эцсийн бүтээгдэхүүний доллар тутмын зөвхөн 19 цент нь фермерт ногдож, 38 цент нь боловсруулалт, худалдаа, 12 цент нь баглаа боолт, тээвэр, 8 цент нь агуулах, техникийн түрээс гэх мэт бусад салбарын нэмүү өртөгт тардаг байна. Хятад гэхэд саяхнаас л хөдөө аж ахуйн илүүдэл ажлын хүч бусад салбарт шилжин шавхагдсанаар цалингийн дундаж өсөж, хямд цалинд түшиглэсэн салбаруудад өрсөлдөх чадвараа Зүүн өмнөд Азийн орнуудал алдаж, илүү өндөр ур чадвар шаардсан салбарт шилжихийг зорьж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ

Уламжлалт аж ахуйгаас зах зээлийн эдийн засагт ямар салбараар дамжин шилжих нь тухайн орны “comparative advantage” буюу харьцангуй давуу тал хаана байхаас шалтгаална. Энд онолын хувьд “Heckscher - Ohlin”-ы сонгодог онол буюу тэр оронд хамгийн элбэг байгаа эдийн засгийн нөөцөд тулгуурласан үйлдвэрлэл, “Intra-Industry Trade” шинэ онол буюу масс үйлдвэрлэж зардлаа багасган, бүтээгдэхүүнээ сурталчилж бусдаас ялгарах үйлдвэрлэл гэсэн гол хоёр чиглэл байдаг. Монголын тухайд хамгийн элбэг нөөц нь газар нутаг, ялангуяа хөрсөн доорх баялаг учир гадаадын хөрөнгө, технологийг татах замаар түүнийгээ эргэлтэд оруулах нь хамгийн бэлэн боломж. Аж үйлдвэрийн бараанд хамаатай хоёр дахь чиглэл нь дотооддоо тийм бүтээгдэхүүн үйлдвэрлэх уламжлал, мэдлэг чадвар, зах зээлийн томоохон цар хүрээ шаардахын зэрэгцээ, олон улсын зах зээлийн өрсөлдөөн илүү хүчтэй байдаг.

Аж үйлдвэржилт анх Англид ноосны наймаачид айлуудад “put out” өгч, хөгшид хүүхэдгүй гэрээрээ утас ээрдэг болсноор үүссэн гэдэг. Зах зээлийн эрэлт, эцсийн хэрэглэгчийн шаардлага л чи юу үйлдвэрлэж чадахыг тодорхойлдог гэсэн энэ логик одоо үед улам чухал болж байна. Өнөөдөр хэрэгцээт бүх л бараа багтахгүй чихэлдэж, Хятад нэгдсэнээс хойш зарим салбарт илүүдэлтэй болж, үнэ өсөхөө больсон олон улсын зах зээлд нэвтрэх гол арга нь Global value chain-д шургах буюу тэнд нэгэнт байраа эзэлсэн том компаниудын захиалгат нийлүүлэгч болох арга болсон байна. Гэвч сүүлийн

үед технологийн өөрчлөлт улам хурдсаж брэнд компани, бүтээгдэхүүн ч хэр удах нь эргэлзээтэй болж байна. Ялангуяа ойрын 5-10 жилд автоматжилт роботчиллын улмаас хүний хөдөлмөрийн эрэлт буурах нь буурай орнуудад илүү хүнд тусах төлөвтэй байна. Гэхдээ нөгөө талаас мэдээллийн технологийн хувьсгалын ачаар мэдлэг мэдээлэл үндсэндээ үнэгүй болж, үйлдвэрлэл ч хүнд механизм, барилга байгууламж бага шаардсан мэдлэгийн ба жингүй эдийн засаг хөгжиж, үйлчилгээний экспорт өргөсөж байгаа нь жижиг дунд үйлдвэрлэгчдэд шинэ боломж нээж байна. Мөн Хятад хөгжсөний ачаар Монгол хөгжих нөхцөл хамгийн хүнд орны нэгээс хамгийн таатай орны нэг болоод байна.

Бид социализмын үед СЭВ-ийн хүрээнд төвлөрсөн төлөвлөлт хуваариар төрийн үйлдвэрүүд байгуулж, бүтээгдэхүүнээ удаан хугацааны гэрээ үнээр худалдаж байлаа. Хөдөө аж ахуйн түүхий эдээ боловсруулж экспортлох замаар хөгжинө гэж олон жил ярьж их ч хөрөнгө зарсан. Гэтэл анхан шатны боловсруулалт хүртэл бусад оронд зөндөө удаан хөгжөөд мэргэшчихсэн байгаа тул улсын үйлдвэрийн савхи, нэхий дээл, консерв, кашмир маань ч олон улсын өрсөлдөөнд цохигдоод байхгүй болсон. Ашигт малтмалын боловсруулалт ч ялгаагүй. Би 1980-аад онд Оросоос нефть авч бензин болгон баруунд зарахаар барьсан Болгарийн refinery зах зээл нээгдмэгц дотооддоо ч авахгүй болж, сэлбэг химийн бодис авсан валютын өрөө төлж чадахгүй хүнд байдалд орсныг үзэж байв.

ЭЦСИЙН ДҮНД ХҮМҮҮС АЖИЛ ХИЙЖ АВАХ ЦАЛИН ОРЛОГО ӨСЧ БАЙЖ Л АМЬДРАЛ САЙЖИРНА, ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖИНӨ. ТӨРИЙН ҮҮРЭГ НЬ ТЭДНИЙ, ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ ХУВИЙН СЕКТОРЫН БИЗНЕС ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭЭД ЗЭРГЭЭР ХАНГАЖ, ХАМГААЛАХ, ГОЛ НЬ ТОМ БАГА, ГАДААД ДОТООД ЯЛГААГҮЙ ЖИГД ТЭГШ НӨХЦӨЛД ЭЛДЭВ СААД ДАРАМТГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ ХАМТАРЧ АЖИЛЛАХ НӨХЦЛИЙГ ХАНГАХАД ОРШИНО.

Социализмаас салахгүй гэж байгаа Хятад ч өнөөдөр алдагдал, өр зээлийн уурхай болсон улсын үйлдвэр, банкуудаа зах зээлд шилжүүлэхийг тулгамдсан зорилгоо болгож, залуучууддаа ажил хайхын оронд багшийн цалин нь хүрэхгүй Алибабаг байгуулсан Жак Ма шиг бизнес эхлүүлэхийг уриалж байна. Бид ч гэсэн юуны түрүүн хувийн сектор хийх ёстой бизнесийн талбарт төр хутгалдаж ордгийг зогсоож, төрөөс хамаарахгүйгээр бизнесийн хуулиар эрх тэгш өрсөлдөх бололцоог бүрдүүлэх хэрэгтэй байна.

“АСУУДЛЫГ НЬ ШИЙДЭЖ” “САНХҮҮЖИЛТИЙГ НЬ ГАРГУУЛЖ” “АЛДАГДЛЫГ НЬ БАРАГДУУЛАХ” БҮРТ УЛСЫН ХӨРӨНГӨ ҮРЭГДЭЖ, ХУВИЙН СЕКТОРЫН ОРЧИН ГАЖУУДАЖ БУСНИУЛАГДАЖ БАЙДГИЙГ САНАЦГААЯ. ТӨРИЙН ХӨРӨНГӨӨР СҮРХИЙ ЮМ ХИЙЕ ГЭЖ УРИАЛЖ БАЙГАА УЛС ТӨРЧИД ҮНЭХЭЭР АШИГТАЙ, АЛДАГДАЛГҮЙ ЮМ БОЛ ХУВИАРАА БИЗНЕС БОЛГОН БАЯЖИЖ ХАРУУЛАХ НЬ ЗҮЙТЭЙ ЮМ. ТЭГЭХГҮЙ БОЛ ТӨР ӨӨРӨӨ АВЛИГЫН ХӨРС БЭЛДЭЖ, ОЛИГАРХИУДЫН ТЭМЦЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ХУВИРАХ АЮУЛТАЙ БАЙНА.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.10.27-ны дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ИХ СУРГУУЛИУДЫГ НЭГТГЭХ НЬ ЗӨВ

Өнгөрсөн Мягмар гарагт “Дээд боловсролын үр өгөөжийг дээшлүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг Төрийн ордонд боллоо. Хэлэлцүүлэгт БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг “Судалгааны Их сургууль байгуулах үзэл баримтлал” илтгэлийг танилцуулсан. Улмаар судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг өрнөж, үүний тулд төрийн өмчийн их сургуулиудыг нэгтгэх асуудлыг хөндсөн.

СУДАЛГААНД СУУРИЛСАН ИХ СУРГУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ?

“Хэфэйн тунхаглал” -д орчин үеийн судалгаанд суурилсан их сургуулийн талаар доорх үндсэн шинжийг нэрлэсэн байдаг.

- нээлттэй засаглалын тогтолцоотой байх, олон улсын хэмжээнд чадварлаг мэргэжилтнийг татах чадвартай шилдэг хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй эрхэм зорилгоо тодорхойлж, стратегийн төлөвлөгөө хэрэгжүүлдэг, судалгаа, сургалтын тэргүүлэх чиглэлээ бие даан тодорхойлох эрхтэй байх;
- судалгааны ёс зүй, түүнтэй холбоотой хэм хэмжээний стандартыг мөрддөг, эрдмийн эрх чөлөөг хариуцлагатайгаар хэрэгжүүлдэг байх;
- судлаачдыг тасралтгүй бэлтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлдэг байх;
- тэргүүлэх салбарт бакалаврын, ахисан түвшний сургалтаар үндэсний болон олон улсын түвшинд инновацийг бий болгох, нэвтрүүлэх чадамжийг бүрдүүлсэн байх;

2018 онд Засгийн Газар судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлэх зорилгоор “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” гэх бодлогын баримт бичгийг баталсан. Энэ хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2019–2023 оны хооронд хэрэгжүүлэх ба 1-р үе 2019 – 2020 онд, 2-р үе 2020 – 2023 онд байна.

Их сургуулиудыг нэгтгэх асуудалтай хамт Шинжлэх ухааны академийг МУИС-ийн дэргэд байлгах тухай асуудал яригдаж байгаа. Төрийн өмчийн МУИС, ШУТИС, ХААИС, МУБИС, Улаанбаатарын их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, АШУУИС гэсэн сургуулиудыг нэгтгэхээр ярьж байна.

СУДАЛГААНД СУУРИЛСАН ИХ СУРГУУЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ гэж байгаа.

- Зорилт 1.** Судалгаанд суурилсан их сургуульд тавигдах шаардлага, шалгуурыг тогтоож, судалгааны үр дүнг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Зорилт 2.** Их сургуулийн засаглал, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг судалгаанд суурилсан их сургуулийн шаардлага болон шалгуурт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Зорилт 3.** Санхүүжилтийн оновчтой эх үүсвэрийг бий болгох, өрсөлдөөнт тэтгэлгийн хэлбэрүүдийг хэрэгжүүлэх;
- Зорилт 4.** Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн орчин үеийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн чадварлаг эрдэмтэн, судлаачдыг судалгаанд суурилсан их сургуулиудад төвлөрүүлэх замаар ахисан түвшний сургалт, судалгааг хөгжүүлэх;
- Зорилт 5.** Судалгаа боловсруулалт, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, дэд бүтцийг сайжруулах замаар инновацийн эко системийг хөгжүүлэх.

Манай ерөнхий боловсрол ба дээд боловсролын систем нь өөрөө 17,18-р зууны тогтолцооноосоо хөдлөөгүй байгаа. Тэр үед боловсролын салбарт ямар ч инноваци хүлээн зөвшөөрдөггүй байсан. Шинэчлэл авчрах асуудал хориотой байсан. 21-р зуунд бид МУ-ын давуу тал, Монгол хүнийг бий болгоё гэвэл юун түрүүнд дээд боловсрол олгодог сургуулиудыг цөөлөхөөс эхлэх ёстой. Монгол улс 3.2 сая хүнтэй, 94 дээд боловсрол олгодог сургуультай. Нэгтгэснээр бид тархай бутархай санхүүгийн болон хүний нөөцийг цэгцэлж чадна. Нэгтгэх асуудлыг дэндүү хожуу эхэлж байна гэж харж байна.

Хариуцлагын хэлбэр	2018
Улсын дүн	94
Төрийн өмчийн	18
Төрийн өмчийн бус	73
Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын сургууль	3

Статистикийн Үндэсний Хороо

СААРАЛ ЖАГСААЛТАД ХЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ВЭ?

УИХ-ын дарга Г.Занданшатар ФАТФ-аас гаргасан зөвлөмжийг манай төрийн байгууллагууд хэрхэн авч хэрэгжүүлсэн талаарх үр дүнг хэлэлцэхээр Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголбанкны удирдлагуудтай өнгөрсөн Лхагва гарагт уулзсан.

УИХ-ын дарга Г.Занданшатар “Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх болон улсын эдийн засгийг тогтворжуулж, санхүүгийн орчныг эрүүлжүүлэх чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргасан боловч гадаадад болон дотооддоо итгэл хүлээлгэхүйц орчин нөхцөл бүрдүүлж, үр дүнд хүрч чадсангүй. Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зэх зээлийн тогтвортой байдлыг хангах, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна гэж үзэж байна. Үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтад эрс шинэчлэл хийх зайлшгүй нөхцөл үүслээ. Тиймээс



өөрийн бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Танд хариуцлага тооцох асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэх шаардлагатай” гэв.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан “УИХ-ын дарга 10-р сарын 23-нд надтай энэ асуудлаар уулзсан. Би санал бодлоо тодорхой хэлсэн. Албан тушаалтай зууралдаад байх хүн би биш. Саарал жагсаалтад орсон асуудалд хариуцлага хүлээхэд бэлэн. Гэхдээ цаана нь гадаад харилцааны тухай

асуудал байна. Монголд хөрөнгө оруулсан компаниудын гомдол ч бас гарсан. Энэ бүгдийг нээлттэй ярьж болохгүй байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр эсвэл хаалттай хуралдаанд ярья” гэв.

Хариуцлага тооцох асуудал дээр битгий улс төржөөсэй гэж бодож байна. Үнэхээр эдгээр хүмүүсийг солих бол саарал жагсаалтад орсныг засах чадвартай боловсон хүчнийг сонгох хэрэгтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН: ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



Өнгөрсөн 22-ны өдөр Монголбанкнаас “Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал” хурлыг зохион байгууллаа.

ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ “Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүд манай улсын татварын нийт орлогын 23 хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөөг илтгэн харуулж байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, хөрөнгө оруулалтыг татах тодорхой зорилтууд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд шинэ хөрөнгө оруулагчдад таатай нөхцлийг бүрдүүлэх, тэдний эрхийг хамгаалах, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэхийн төлөө бид ажиллаж байна” гэв.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан “Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал 2017 оноос тогтворжсон. 2019 оны эхний хагас жилийн байдлаар ДНБ 7.3 хувиар өслөө. Гэсэн хэдий ч түүхий эдийн үнийн савалгаа, гадаад өрийн эрсдэл өндөр хэвээр байна. Тиймээс экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх хөтөлбөрүүдэд нэмэлт эх үүсвэрүүд болон гадаадын шууд хөрөнгө оруулалт татах таатай орчин бий болгох нь нэн тэргүүний асуудал болоод байна” гэв.

Эдийн засагч Н.Энхбаяр “Саяхан Хятад улсын хөгжил, шинэтгэлийн хороо хоёр ч уурхай нээж байгаагаа зарлаж байна. Манайх ирэх жилийн төсвийн орлогыг төсөөлөхдөө үүнийг тооцоогүй. Энэ уурхайнууд ашиглалтад орчихвол 42 сая тонн нүүрс экспортолно гэдэг тоо буураад л явна. Тиймээс хөрш орныхоо бодлого, зохицуулалттай уялдуулж төсвөө тооцож, төсөөлөхгүй бол бид арай л өөдрөг хараад байна.” гэсэн.

Хийсэн ажил нь хангалттай түвшинд биш байж л, яг нөгөө ярьдаг зүйлээ ярьсаар л байдаг дэндүү хурал, форумын орон болчихсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com